

**Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын хамтрагч байгууллага**  
**“Монголын төмөр зам” ТӨХК-ийн статусын тухай**  
**ОСЖД-ийн Хороо**  
**болон**  
**“Монголын төмөр зам” ТӨХК-ийн хооронд байгуулсан**  
**ХЭЛЭЛЦЭЭР**

Нэг талаас ОСЖД-ийн Хороо, нөгөө талаас “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “МТЗ” ТӨХК, хамтад нь Талууд/ ОСЖД-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 5 дугаар заалтыг үндэслэн мөн ОСЖД-ийн гишүүдийн нэгдмэл сонирхолд үйлчлэх техник, ашиглалт, эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд дэм үзүүлэхээр дараах зүйлүүдийг харилцан тохиролцов:

**1-р Зүйл**

1. Төмөр замуудын Ерөнхий захирлуудын /хариуцлагатай төлөөлөгчдийн/ 31 дүгээр бага хурлын 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн шийдвэрийн дагуу “МТЗ” ТӨХК ОСЖД-ийн хамтрагч байгууллага гэх статустай болсон бөгөөд үндсэн хэлэлцээрийн дагуу Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд тээврийн бодлого, хөгжлийн стратеги, тээврийн тухай хууль болон ачаа тээвэрлэлт зэрэг дээр хамтран ажиллах юм.

2. Талууд болох ОСЖД-ийн гишүүд болон “МТЗ” ТӨХК нь харилцан санал нэгдсэний үндсэн дээр үндсэн хэлэлцээрт өөр/бусад чиглэлийн хүрээнд хамтран ажиллах боломжтой юм.

**2-р Зүйл**

1. ОСЖД-ийн хорооноос “МТЗ” ТӨХК нь дараах ерөнхий баримт бичгийг хүлээн авах болно:
2. ОСЖД байгууллагын хуралд “МТЗ”ТӨХК оролцсон тохиолдолд тус компанийн төлөөлөгчид баримт бичгүүд хүлээн авах бөгөөд мөн “ОСЖД Бюллетель” сэтгүүлийг хүлээн авах болно. Бүх хүлээлгэн өгөх баримт бичгүүд нэг хувь орос хэл дээр байх болно.
3. ОСЖД-ийн хороо “МТЗ” ТӨХК-аас үндсэн хэлэлцээрийн 1-ийн 1 дүгээр заалтын хүрээнд ОСЖД-ийн гишүүдэд шаардлагатай мэдээллийг орос хэл дээр хүлээн аван танилцуулна.

**3-р Зүйл**

1. ОСЖД-ийн хамтрагч байгууллага болох “МТЗ” ТӨХК нь ОСЖД-ийн зохион байгуулж буй хуралд ОСЖД-ийн хорооны урилгаар оролцох эрхтэй бөгөөд, мөн үндсэн хэлэлцээрийн 1-ийн 1 дүгээр заалтын дагуу шаардлагатай баримт бичгийг боловсруулна.

2. “МТЗ” ТӨХК ОСЖД-ийн байгууллагын хурал дээр санал өгөх эрхтэй юм.

3. ОСЖД-ийн хорооны урилгаар “МТЗ” ТӨХК Төмөр замын Ерөнхий захирлуудын бага хуралд /үүрэг хүлээсэн төлөөлөгчид/ зочноор оролцож болно.

**4-р Зүйл**

1. Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг болох ОСЖД-ийн хороо болон “МТЗ” ТӨХК-ийн тусгай протоколын дагуу харилцан санал нэгдсэний үндсэн дээр ОСЖД-ийн хамтрагч байгууллага болох “МТЗ” ТӨХК нь санхүүгийн хураамжийг төлөх болно.

**5-р Зүйл**

1. Тухайн хэлэлцээр хугацаа заагаагүй болно.
2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэлэлцээрийг өөрчлөх эсвэл нэмэлт өөрчлөлтийг хийж болно. Хэлэлцээрт өөрчлөлт болон нэмэлт өөрчлөлт оруулахад саналын дагуу нэмэлт өөрчлөлт хийх бөгөөд үндсэн хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг байх юм.

3. Хэлэлцээртэй холбоотой асуудлыг талууд харилцан хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ.
4. Талууд тус бүр үндсэн хэлэлцээрт үүргээ биелүүлэх заасан хугацаа хэтрэх буюу 6 сараас багагүй хугацаанд нөгөө талд мэдэгдсэний үндсэн дээр хэлэлцээрийг цуцлах эрхтэй юм.
5. Үндсэн хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.  
Үндсэн хэлэлцээр Варшав хотод 2016 онд 2 хувь орос хэл дээр үйлсэн болно.